2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,210,293.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,210,293.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	102,210,293.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	102,210,293.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,149,425.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	94,211,520.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,560,780.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	288,568.00
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ сум ТТЗ нь 2022 оныг "Эмх цэгц дэг журмыг сахих ба сахиулах жил" болгон зарлаж Иргэдээ дээдэлсэн ухаалаг үйлчилгээг нэвтрүүлэх" гэсэн зорилт тавин ажиллажээ.

Мөн сумын төсөвт байгууллагуудын төсвийн орлого зарлага зарцуулалтын үйл ажиллагаа төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих удирдлагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх бодит мэдээ мэдээллээр хангах зорилгыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Сумын хэмжээнд 2022 онд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн биелэлт 73.6 хувь, аймгийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 77.9 хувиар, сумын засаг даргын мөрийн хөтөлбөр 92.3 хувиар тус тус биелсэн гүйцэтгэлтэй дүгнүүлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Архив бичиг хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, НББ-ийн тухай хууль болон бусад тогтоол шийдвэрийг мөрдөн ажилласан байна.

Мөн Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн захирагч нарт төсвийг хэмнэлттэй зарцуулах үүрэг өгч ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4251.9 сая төгрөгөөр буюу 72 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	220.9	351.4	130.5
Авлага	347.8	243.6	-104.2
Бараа материал	418.9	88.3	-330.6
Үндсэн хөрөнгө	4923.1	959.9	-3963.2
Нийт хөрөнгө	5910.8	1658.9	-4251.9
Өр төлбөр	4.1	5.6	-1.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5906.7	1653.3	-4253.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5910.8	1658.9	-4251.9

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 330.6, үндсэн хөрөнгө 3963.2 сая төгрөгөөр буурч нийт хөрөнгийн хэмжээ 4251.9 сая төгрөгөөр буурсан нь ЭМТ, Соёл, Сургууль Цэцэрлэгийн байгууллагууд орон нутагт нэгтгэгдэхгүй болсонтой холбон үзэж байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 220.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 351.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж 130.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө			
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	220.9	351.4	130.5
Арилжааны банк дахь харилцах			
Гадаад валют			
Арилжааны банк дахь харилцах			
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Дүн	220.9	351.4	130.5

Эх сурвалж: [Мөнгөн хөрөнгийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан](#)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 351.4 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд үлдэгдэлтэйгээр тайлагнажээ

Аудитын илрүүлэлт

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчил илрээгүй болно.

3.5.2 Авлага

Авлагын эхний үлдэгдэл 347.8 сая төгрөгийн, эцсийн үлдэгдэл 243.5 сая төгрөг болж 104.3 сая төгрөгөөр буурсан нь ЭМТ, Цэцэрлэг, Сургууль, Соёлын төв гэсэн байгууллагууд санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдээгүй хасагдсантай холбоотой байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0.3	0	-0.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	120.4	0	-120.4
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	16.7	16.5	-0.2
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.001	0.001	0
Татаас, санхүүжилтийн авлага			
Байгууллагаас авах авлага	27.4	13.8	-13.6
Хувь хүмүүсээс авах авлага	183.0	213.2	30.2
Дүн	347.8	243.5	-104.3

Эх сурвалж: Авлагын 2022 [оны санхүүгийн нэгтгэсэн тайлан](#)

Дээрх авлагаас сумын ерөнхий орлогын дансанд 9.4, ХХС-гийн данст 225.9, ЖДҮДС-гийн дансанд 8.2 сая төгрөгийн авлагууд тус тус эзэлж байна.

Дээрх авлагаас сумын ОНЕО данст ХХС-гийн 9.4 сая төгрөгийн авлага нь хэдэн онд үүссэн, төлөгдөх эзэн нь тодорхойгүй авлагын үлдэгдэлтэй тайлагнасан зөрчилд албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Аудитын илрүүлэлт

Тус сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар ХХС-ийн санхүүгийн тайланд 9.4 сая төгрөгийн авлагыг тусгаж тайлагнаагүй, хэдэн онд үүссэн, эзэн холбогдолгүй авлагыг одоо хүртэл барагдуулж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлж ажилласан.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа төлбөртэй холбоотой дансны авлага өглөг үүсээгүй болно.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 419.0 сая төгрөг, [эцсийн үлдэгдэл](#) 88.3 сая төгрөг болж, 330.6 сая [төгрөгөөр](#) буурсан нь ЭМТ, Соёл, Сургууль Цэцэрлэгийн байгууллагууд орон нутагт нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	88.4	0	-88.4
Тусгай зориулалттай материал	2.1	0	-2.1
Эм боох материал	86.3	0	-86.3
Дуусаагүй үйлдвэрлэл	0	0	0
Бэлэн бүтээгдэхүүн	0	0	0
Хангамжийн материал	318.9	80.4	-238.5
Бичиг хэргийн материал	0.1	0.1	0
Аж ахуйн материал	61.8	38.1	-23.7
Сэлбэг хэрэгсэл	0	4.0	4.0
Түлш, шатах тослох материал	13.7	0	-13.7
Барилгын засварын материал	3.6	0	-3.6
Хүнсний материал	39.7	0	-39.7
Бусад хангамжийн материал	199.9	38.2	-161.7
Мал амьтад	11.6	7.8	3.8
Дүн	418.9	88.3	-330.6

Эх сурвалж: Бараа материалын 2022 [оны санхүүгийн нэгтгэсэн тайлан](#)

Тайлант онд бараа материалыг төсвийн хөрөнгөөр 182.9 сая төгрөгөөр худалдан авч, үнэ төлбөргүй хандиваар 12.1 сая төгрөгийн бараа материалыг тус тус орлого авч тайлагнажээ.

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 11/06 тоот тогтоолоор цаашид ашиглах боломжгүй 5.2 сая [төгрөгийн](#) бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Аудитын илрүүлэлт

Сумын ТТЗ-ийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар ОНХС-гаар бэлтгэсэн 3577.5 мянган төгрөгийн материалыг шилжүүлэх тогтоол шийдвэр гаргаагүй байхад шилжүүлснээр тайлагнасан алдаа илэрснийг аудитын явцад залруулж ажиллалаа.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэлгүй болно.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад			
Дүн			

Эх сурвалж:

Аудитын илрүүлэлт

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4923.1 сая төгрөг, [эцсийн үлдэгдэл](#) 975.7 сая төгрөг болж, 3947.4 сая [төгрөгөөр](#) буурсан нь ЭМТ, Соёлын төв, сургууль, цэцэрлэг гэсэн төсөвт байгууллагууд салбар, салбарын нэгдсэн тайланд нэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4794.4	959.9	-3834.5
Барилга, байгууламж, орон сууц	4052.8	379.7	-3673.1
Авто-тээврийн хэрэгсэл	456.8	383.7	-73.1
Машин тоног төхөөрөмж(компьютер)	816.5	260.1	-556.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	181.4	12.8	168.6
Бусад үндсэн хөрөнгө	376.2	315.3	60.9
Дуусаагүй барилга, байгууламж			
Биет бус хөрөнгө	128.7	15.8	-112.7
Программ хангамж	9.9	3.1	6.8
Бусад биет бус хөрөнгө	121.9	13.8	108.1
Бусад хөрөнгө /ТӨҮГ/			
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/			
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад			
Дүн	5910.8	1658.9	-4251.9

Эх сурвалж: Үндсэн хөрөнгийн 2022 [оны санхүүгийн нэгтгэсэн тайлан](#)

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 100.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 29.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авч, 27.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй буюу хандиваар орлого авч үндсэн хөрөнгийг нийт 156.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 3947.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хассанаар тайлагнасан нь эрүүл мэнд соёлын байгууллагууд нь харьяа салбартаа нэгтгэгдсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй барилга дансанд үлдэгдэл хөрөнгөгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Тус сумын БХС-гийн хөрөнгөөр бэлтгэгдсэн 6480.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэх тогтоол шийдвэр гаргаагүй байхад ЗДТГ-т шилжүүлснээр бүртгэж тайлагнасан алдаа илэрснийг аудитын явцад залруулж ажиллалаа.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 4.1 сая төгрөгийн, эцсийн үлдэгдэл 5.6 сая төгрөг болж, 1.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татварын өглөг	0.9	4.1	2.8
Байгууллагад төлөх өглөг	0.4	0	0
Ажилчидтай холбоотой өглөг	2.4	1.5	-0.9
Бусад	0.4	0	-0.4
Дүн	4.1	5.6	

Эх сурвалж: Өр төлбөрийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх өглөгийг “Ингэт дөл” ОНӨААТҮГ нь санхүүгийн тайландаа өглөгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Урт хугацаат өр төлбөрийн данс үлдэгдэлгүй болно.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөртэй холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5910.8, эцсийн үлдэгдэл 1659.0 сая төгрөг болж 4251.8 сая төгрөгөөр буурсан нь Эрүүл мэнд, соёл, боловсролын байгууллагууд нь харьяа салбартаа нэгтгэгдсэн холбоотой байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1943.1	812.8	1130.3
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1595.6	465.3	0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	347.5	347.5	0
Хуримтлагдсан үр дүн	1781.2	442.4	-1338.8
Өмнөх үеийн үр дүн	950.6	318.8	631.8
Тайлант үеийн үр дүн	830.6	123.7	706.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2182.4	398.1	-1784.3
Дүн	5906.7	1653.3	-4253.4

Эх сурвалж: Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 812.3 сая төгрөг болж 1130.3 сая төгрөгөөр буурсан нь эрүүл мэнд, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагууд нь харьяа салбартаа санхүүгийн тайлангаа нэгтгүүлсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 398.1 сая төгрөг болж 1784.3 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн байгууллагуудаас бусад байгууллагуудын хөрөнгийн дахин үнэлгээ салбарууддаа шилжиж тайлагнасанатай холбоотой болно.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэлгүй болно.

Хуримтлагдсан үр дүн 442.5 сая төгрөг болж 1338.7 сая төгрөгөөр буурсан нь бүтцийн өөрчлөлтөөр хөрөнгө хасагдаж тайлагнасанатай холбон үзэж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 258.8, орон нутгийн төсвөөс 1649,5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1147.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн нийт зардлын дүнг 884.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2031.7 сая төгрөгөөр тодотгол хийж өөрчилжээ.

Энэ нь ТҮ-1-3 шатлалаар цалинждаг гэрээт ажилчдыг орон нутгийн байгууллагад нэгтгэхээр шийдвэр гарч гэрээт ажилчдын цалин, НДШ, тогтмол зардал болон төрийн үйлчилгээний цэвэрлэгээний зардлуудыг нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 27 арга хэмжээнд 2031.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1496.7 сая төгрөгийг урсгал зардалд, урсгал шилжүүлэгт 22.3, бараа үйлчилгээний бусад зардалд 169.5, хөрөнгийн зардалд 343.3 сая төгрөг зарцуулахаар тус тус төлөвлөн батлуулжээ.

Нийт зардлыг эх үүсвэр тус бүрээр харуулбал:

Орон нутгийн төсвөөс 1649.6, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 382.2 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлэхээр батлуулсан байна.

Гүйцэтгэлээр 1663.4 сая төгрөгийг улсын /орон нутгийн төсвөөс, 155.0 сая төгрөгийг нийт 1818.4 сая төгрөгийн санхүүжилтийг авч батлагдсан зардлаас 213.4 сая төгрөгөөр хэмнэж ажиллажээ.

Үндсэн үйл ажиллагааны орлого 155.0 сая төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 227.2 сая төгрөгөөр дутуу орлого бүрдүүлсэн нь ЖДҮДС болон ХХС-гийн эргэн төлөлтийн авлага бүрэн ороогүйтэй холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого ЗДТГ нь 0.3 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 0.2 сая төгрөгийн орлого оруулж 90 хувийн биелэлтэй тайлагнажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл бодит зардлаар 1804.4 сая төгрөг буюу 88.8 хувийн гүйцэтгэлтэй буюу батлагдсан зардлаас сая төгрөгөөр хэмнэсэн үзүүлэлтэй байна.

Үүнд: Хэмнэгдсэн зардлуудыг дурдвал:

Цалин хөлс нэмэгдэл цалинд 28.1 сая, НДШ-ийн зардалд 3.3 сая, хөрөнгийн зардал 112.5, шуудан холбооны зардал 0.2, ХХС-гаас олгох зээл 69.0 сая төгрөгийг тус тус хэмнэж ажиллажээ.

Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1818.4 сая төгрөг буюу 14.0 сая төгрөгийн зөрүү дүн сумын ИТХ нь түлш халаалтын зардлыг 2.0, Соёлын төв 12.0 сая төгрөгөөр илүү зарцуулалт хийгдэж гүйцэтгэлийн тайланд Соёлын төв нь дээд шатны байгууллагад нэгтгэгдсэнтэй холбоотойгоор буурч тайлагнасан.

Энэ нь байр ашиглалтай холбоотой тогтмол зардал хүрэлцэхгүй буюу тодотгол хийж батлуулаагүй, төлөвлөсөн зардлаас илүү зарцуулалтын эрх нээсэнтэй холбон үзэж байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Здтг -Үндсэн үйл ажиллагаа	418.4	396.2	22.8	94.7
2	Баг хорооны засаг дарга	65.5	65.7	1.7	100.3
3	Нийтлэг үйлчилгээ	37.5	37.5	0	100
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	11.8	11.8	0	100
5	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдөх	4.9	4.9	0	100
6	Бусад тоног төхөөрөмж	23.0	23.0	0	100
7	Орон нутгийн нөөц хөрөнгө	35.0	35.0	0	100

/сая төгрөгөөр/

8	Хур хог хаягдал орчны бохирдол	4.0	4.0	0	100
10	Улсын баяр наадам	10.0	10.0	0	100
11	ИТХ -Үндсэн үйл ажиллагаа	4.6	4.4	0.2	94.6
12	Ажил олгогчоос олгох тэтгэмж	0.2	0.2	0	100
13	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдөх	5.4	5.4	0	100
14	Багийн ИНХ даргын урамшуулал	6.7	6.7	0	100
15	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	6,0	1,6	4,4	26,8
16	Цэц -төрийн өмчийн барилгын тогтмол зардал	67,2	67,2		100
17	Нийтлэг үйлчилгээ	55,8	55,8		100
18	Сур -төрийн өмчийн барилгын тогтмол зардал	337,7	337,7		100
19	Нийтлэг үйлчилгээ	670,1	670,1		100
20	ЭМТ -төрийн өмчийн барилгын тогтмол зардал	529,8	529,8		100
21	ОНХС Итгэлцүүр	172,7	172,7		100
22	Ашиглалтын тусгай зөвшөөрөл	6,5	6,5		100
23	Мал	119,6	43,1	76,5	36
24	Бусад	21,1	21,1	0	100
25	БХС Байгаль орчин нөхөн сэргээх	66,7	81,4	58,6	122
26	ХХС-эргэн төлөгдөх зээл	161,8	60,5	101,3	37,4
27	ЖДҮ сан	30,0	11,3	18,7	37,7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн тайлангаар 102.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч гүйцэтгэлээр Сэлэнгэ мөрний гүүрний засварт 50.0, зам засварт 30.0, засварын материалд 2.5, цэвэр усны шугамын зураг төсвийн үнэд 5.0, хог цэвэрлэгээнд 1.5, ХАА-н тооллогын зардалд 4.6, ундны усны түгээлтийн хөлсөнд 3.1, бусад зардалд 0.6, морин эргүүлийн зардалд 4.9 сая төгрөгийг тус тус нэмэлт дансаар зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Суманд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдал үүсээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/39 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүжилтийн дүнгийн 3620.9 сая төгрөгөөс 75 хувиар буюу 40.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2 орон тоог бууруулан ажиллаж, цалингийн зардлыг 28.1, бараа үйлчилгээний зардлыг 45.7 сая төгрөгөөр, авлагыг 104.2, 4.1 сая төгрөгөөр тус тус барагдуулж батлагдсан төсвөөс зардлыг 213.4 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлэх мэдээллүүдээс 4 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөв.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус сумын БХС-гийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад шатахууны даргын цохолтгүй, жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу 117.5 мянган

төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 3 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоов.

Тус сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар БХС-гийн зарцуулалтыг тулгахад удирдлага штабын шуурхай командын бүрэлдэхүүнийг томилж анхны тусламжийн нөхөрлөл багт 18 ширхэг хантааз 270.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-д “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, Байгал хамгаалах Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд заруулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3 дугаар зүйлийн 7-д “Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоов.

Сэлэнгэ сумын ЖДҮДС-гаас 2022 оны байдлаар 7 иргэнд 8.0 сая төгрөгийн зээл олгосон боловч тус зээл нь зориулалтын дагуу хэрэгжсэн эсэх хяналт тавьж ажиллаагүй хэрэгжилтийн тайлан мэдээ байхгүй нь НББ-ийн тухай хуулийн НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 3 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж хүргүүлэв.

Тус сумын ЖДҮДС-гаас олгосон иргэдийн зээлийн эцсийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж ажиллаагүй нь НББ-ийн тухай хуулийн НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж хүргүүлэв.

БХС-гийн орлогыг ойжуулалт хийгдсэн иргэд, аж ахуй нэгжээс орсон орлогоор тайлагнадаг ч тухайн иргэн аж ахуйн нэгжээс орох орлогыг тулган баталгаажуулж ажилладаггүй, авлага, өглөгийн тооцоо хийгддэггүй, гүйцэтгэлийн тайланд хяналт тавьж баталгаажуулдаггүй, ойжуулалт хийгдсэн тайлан мэдээ байхгүй, тодорхойгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 3 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээллээс 4 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн нь шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	47.4	2	47.4	100
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	3	11.9	3	11.9	100
Нийт дүн	5	59.3	5	59.3	100

Төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 03/125 тоот албан бичгээр хэрэгжилтийн хариуг ирүүлсэн байна.

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ХХС-гийн олон жил болсон, холбогдох эзэн тодорхойгүй авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж ажилласныг дараагийн аудитаар шалгах асуудалд оруулах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.4 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 4 зөвлөмж өгч, 6.5 сая төгрөгийг залруулж ажиллалаа.

Үүнд: Үндсэн хөрөнгийн тайланд тушаал шийдвэргүйгээр 6.5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлснээр тайлагнасныг залрууллаа.

Аудитаар 0.4 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 2 төлбөрийн акт, 4 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тус сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар БХС-гийн зарцуулалтыг түүвэрлэлтийн горим сорилоор 117.5 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг даргын цохолтгүй, жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, мөн төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, 270.0 мянган төгрөгөөр нөхөрлөл багийн гишүүдэд хантааз худалдан авч олгосон зэрэг зөрчил илэрсэнд 2 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ЖДҮДС-тай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ЖДҮДС-гаас олгосон зээлийг зориулалтын дагуу зарцуулсан тайлан мэдээг хавсаргаж баримтжуулаагүй.

1.2. Өгсөн зөвлөмж:

ЖДҮДС-гийн хэрэгжилтийн тайлан мэдээг гаргаж, АШБ-ыг бүрдүүлж ажиллах.

2. ЖДҮДС-гийн зарцуулалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

ЖДҮДС-гийн зээл олгосон иргэдийн зээлийн эцсийн үлдэгдлийг тооцон баталгаажуулж ажиллаагүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж

ЖДҮДС-гийн зээлийн үлдэгдлийг иргэдтэй хагас бүтэн жилд тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулан ажиллах.

3. БХС-гийн зээлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

БХС-гийн орлогыг ойжуулалт хийгдсэн иргэд, аж ахуйн нэгжийн орлоготой тулган баталгаажуулдаггүй, авлага өглөгийн тооцоо хийдэггүй, ойжуулалт хийсэн гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан тухай тайлан мэдээг хөтөлж гаргаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж

БХС-аас ойжуулалт хийсэн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж орлогыг бодитой тооцох.

4. Шилэн данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Шилэн дансанд мэдээлэх мэдээллээс 4 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.2 Өгсөн зөвлөмж

Шилэн дансанд мэдээлэх мэдээллийг хугацаанд нь мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

ЖДҮДС-аас 7 иргэнд 8.0 сая төгрөгийн зээл олгосон боловч тус зээл нь зориулалтаар хэрэгжсэн тайлан мэдээг хавсаргаагүй байна.	1	0					1	0				
ЖДҮДС-аас олгосон иргэдийн зээлийн үлдэгдлийг баталгаажуулж тооцоо нийлж ажиллаагүй байна.	1	0					1	0				
БХС-гийн орлогыг иргэн аж ахуй нэгжтэй тооцоо нийлж баталгаажуулдаггүй, хяналт хийсэн тайлан мэдээ байхгүй.	1	0					1	0				
Даргын цохолтгүй, жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй шатахуун зарцуулсан.	1	117.5	1	117.5								
Дүн	4	117.5	1	117.5			3	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Шилэн дансны мэдээг хугацаанд нь мэдээлээгүй.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
БХС-гийн хөрөнгөөс 18 ширхэг хантааз 270.0 мянган төгрөгөөр худалдан авс	1	270.0	1	270.0				
Дүн	1	270.0	1	270.0				
Нийт дүн	2	0	1	270.0			1	0